

ХӨДӨӨ АЖ АХУЙН  
МАХНЫ САЛБАРЫН  
Танилцуулга

Хөрөнгө оруулалт, худалдааны газар

## Contents


<b>1. Удиртгал</b> .....	3
<b>2. Бодлогын баримт бичгүүд</b> .....	5
<b>3. Өнөөгийн нөхцөл байдал</b> .....	7
<b>3.1. Монголын эдийн засгийн экспортын өнөөгийн байдал</b>	
<b>3.2. Монголын махны экспортын өнөөгийн байдал</b>	
<b>4. Нөөц түүхий эд, үйлдвэрлэлийн суурь</b> .....	10
<b>4.1. Монгол Улсын махны экспортын нөөц</b>	
<b>4.2. Монгол улсын махны үйлдвэрлэлийн суурь</b>	
<b>5. Дотоод, гадаад, зах зээлийн боломж</b> .....	11
<b>5.1. ЕАЭЗХ-тай байгуулсан эдийн засгийн хэлэлцээр</b>	
<b>5.2. Төрөөс хэрэгжүүлж байгаа үндэсний хөтөлбөрүүд</b>	
<b>6. Хөрөнгө оруулалтын боломжтой чиглэл</b> .....	12
<b>7. Нэмүү өртөг шингээх боломж</b> .....	12
<b>8. Дэд бүтэц, ханган нийлүүлэлт</b> .....	14
<b>9. Эрсдэл, импортын хорин болон татварын дарамт</b> .....	15
<b>9.1. Махны салбарт тулгамдаж буй асуудлууд</b>	
<b>9.2. Экспортын мах, махан бүтээгдэхүүний гаалийн хорио цээрийн хяналт</b>	
<b>9.3. Махны салбарын байгаль орчинд үзүүлэх нөлөө</b>	
<b>10. Дүгнэлт, санал</b> .....	20

Олон мянган жил мал аж ахуй эрхэлсэн арвин түүхтэй Монгол Улсын хувьд хамгийн үнэ цэнэтэй баялгийн нэг нь мал сүрэг бөгөөд түүнээс мах, махан бүтээгдэхүүн экспортод гаргах асар их нөөц бололцоо байгаа ч хараахан ашиг тусыг нь хүртээгүй байна. Гол төлөв бог малаас (85%) бүрддэг Монгол Улсын мал сүргийн тоо 2025 онд 58.1 сая болж тоологдсон бөгөөд нэг хүнд ногдох малын тоогоор дэлхийд дээгүүрт ордог. Тус салбар нь улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд чухал хувь нэмэр оруулж, хүн амын амьжиргаа, хоол тэжээл, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чухал хувь нэмэр оруулдаг салбар юм.

Тус улсын соёлын өвийн салшгүй нэг хэсэг болсон мал аж ахуй, мах үйлдвэрлэлийн салбар нь экспортыг төрөлжүүлэх таатай боломжийг бүрдүүлдэг юм. Мах, махан бүтээгдэхүүнийг дараах байдлаар ангилж боломжтой байна.

Монгол Улсын мах, махан бүтээгдэхүүний стратеги нь адуу, үхрийн мах, хонь, ямааны махнаас гаргаж авсан төрөл бүрийн боловсруулсан бүтээгдэхүүн, тэр дундаа дайвар махыг багтаасан цогц бүтээгдэхүүнээс бүрдэнэ. Мах, махан бүтээгдэхүүнийг хамгийн бага хэмжээний боловсруулалттай мах, боловсруулсан махан бүтээгдэхүүн гэсэн хоёр өөр сегментэд ангилж болно. Монгол улсын мах, махан бүтээгдэхүүний салбарт үхэр, адуу, хониноос бусад амьтны гаралтай бүтээгдэхүүн, тухайлбал шувуу, агнуурын мах, малын бус гаралтай бүтээгдэхүүн хамаарахгүй.<sup>1</sup>

БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗУРАГЛАЛ- МОНГОЛ ДАХЬ МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТ



<sup>1</sup> Мах, махан бүтээгдэхүүний экспортын стратеги 2024-2028

## Боловсруулаагүй мах

Энэ сегментэд махны төрөлхийн шинж чанар, амтыг хадгалсан, хамгийн бага боловсруулалт хийгдсэн түүхий, боловсруулаагүй махан бүтээгдэхүүн багтана. БТКУС код 02-ын дагуу ангилсан хамгийн бага хэмжээний боловсруулалттай махан бүтээгдэхүүн нь шинэхэн, хөргөсөн болон хөлдөөсөн зүсмэл болон гулууз махнаас бүрдэнэ.

- Адууны мах (БТКУС0205): 5,2 сая толгой адуун сүргийн ашиг тусыг хүртэж, дэлхийн хэмжээнд адууны мах үйлдвэрлэж, хэрэглэдэг цөөн орны нэг учраас энэ ангилал нь БНХАУ, Орос, Казакстан зэрэг Евро Азийн орнуудад нийлүүлэх экспортын нөөц бололцоотой.
- Үхрийн мах (БТКУС0201) (хөргөсөн) ба (БТКУС0202) (хөлдөөсөн): Монгол орны бэлчээр, байгалийн үржүүлгийн арга нь үхрийн махыг чанар, хүнсний аюулгүй байдлын хатуу чанд шаардлагыг хангасан эрүүл мэндийг эрхэмлэгч хэрэглэгчдэд экспортлох эн тэргүүний бүтээгдэхүүн болгон гаргах боломжтой.
- Хонины мах (БТКУС0204): Монгол хонины махны онцгой чанар нь жинхэнэ, дээд зэрэглэлийн махан бүтээгдэхүүн хайж буй зах зээлд тэр дундаа Ойрхи Дорнодын зах зээлд чиглэгдэх боломжийг харуулж байна.
- Үрхийн цагаан идээ (БТКУС0206): Хоол хүнс болгон ашигладаг гэдэс, дотор эрхтэн нь Алс, Дорнод ялангуяа Япон, Хонг-Конг дах эдгээр бүтээгдэхүүний өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээнд тулгуурлан экспортыг төрөлжүүлэх боломжийг олгодог. Хонь, ямааны өлөн нь (БТКУС0405) зах зээлийн чухал сегментийг төлөөлдөг бөгөөд нарийн гэдэсний хуйлмал хэлбэрээр зарагддаг бөгөөд ихэвчлэн Европын Холбоо хиам үйлдвэрлэгчдэд зарагддаг.

Боловсруулсан махан бүтээгдэхүүн

Энэ сегментэд амт, бүтэц, хадгалах хугацааг сайжруулахын тулд өөрчилсөн махыг оруулна. (БТКУС01602)-д ангилагдсан дараах бүтээгдэхүүнүүд (гэрийн тэжээвэр амьтдын хоолноос бусад ) энэ сегментэд багтана.

- Адууны хатаасан мах, утсан үхрийн мах, хонь үхрийн махан жерки зэрэг хатаасан, утсан мах
- Адуу, үхэр, хонины махаар хийсэн утсан хиам, салями, хүйтэн зүсмэл зрэг хиам, дели маягийн мах.
- Даршилсан, амталсан-чанаагүй болон урьдчилсан чанаж болгосон – даршилсан адууны махан шорло, амталсан үхрийн мах, ургамлын амт шингэсэн хонины мах зэрэг мах, даршилсан болон амталсан дотор эрхтний бүтээгдэхүүн
- Хоол хийхэд бэлэн хоол, өөрөөр хэлбэл нэмэлт бэлтгэл шаарддаггүй бүрэн болгож, амталсан бүтээгдэхүүн. Жишээлбэл, жигнэсэн, шарсан мах зэрэг адууны мах, үхэр хонины мах.
- Лаазалсан болон нөөшилсөн мах, түүний дотор лаазалсан шөл, пате, адууны мах, үхэр хонины махан бүтээгдэхүүн зэрэг нь хадгалах хугацааг уртасгаж, тав тухтай байдлыг хангадаг.
- Амьтны хоол (БТКУС2309): Адуу, үхэр, хонины мар, дотор эрхтний махаар бэлтгэсэн бөгөөд гэрийн тэжээвэр амьтдын өндөр чанартай тэжээлийн өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангана. Гэрийн тэжээвэр амьтантай хүмүүс улам бүр нэмэгдэж, тэжээвэр амьтантай хүмүүс улам бүр нэмэгдэж, тэжээвэр амьтдын сайн

сайхан аж байдлыг эн тэргүүнд тавихын хэрээр тэжээвэр амьтдын хоол хүнс, ялангуяа Алс Дорнодод маш их эрэлттэй байдаг.<sup>2</sup>

## 2. Бодлогын баримт бичгүүд

### ***Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 1 дэх хэсэг***

“Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна” гэж, мөн зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна” гэж тус тус заасан<sup>3</sup>.

### ***Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2-т***

“Цөөн зах зээл, цөөн нэр төрлийн бүтээгдэхүүний экспорт, импортоос хэт хамааралтай үндэсний эдийн засгийн эмзэг байдлыг бууруулна. Нэг орноос худалдан авах бараа бүтээгдэхүүн нийт импортод хэт давамгайлахаас сэргийлэх бодлого баримтална. Бүс нутгийн болон олон улсын интеграцид нэгдэх, чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах асуудлыг эдийн засгийн аюулгүй байдал, хөгжлийн шаардлагыг харгалзан, судалгаа, тооцоонд тулгуурлан, шат дараатай, сонголттойгоор хэрэгжүүлнэ” гэж тус тус заасан.<sup>4</sup>

### ***Алсын хараа-2050, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого Зорилго 4-т***

“Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга зонхилсон, ядуурал эрс буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, дотоод хэрэгцээгээ өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай улс болно” гэж заасан бөгөөд энэ зорилгын хүрээнд нийцүүлэн тодорхойлсон эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг төрийн бодлогоор онцгойлон дэмжихээр тусгасан<sup>5</sup>.

Уг зорилгын хэрэгжүүлэх I үе шат (2021-2030)-нд эдийн засгийн бүтцийн шинэчлэлтийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, импортыг орлох болон экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх ба үүнээс “7.Эдийн засгийн хөгжлийн дэмжих эрчим хүч, инженерийн дэд бүтцийг хөгжүүлсэн байна” гэж мөн “8.Цахилгаан станцуудыг өргөтгөж, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, шинэ эх үүсвэрийг барьж, цахилгаан эрчим хүчээр дотоодын хэрэгцээг бүрэн хангасан байна.” гэж тус тус заасан.

### ***Шинэ сэргэлтийн бодлого***

Тус бодлогын Зорилт 3.5-т хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний нөөцтэй уялдуулан боловсруулах үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар хагас

<sup>2</sup> Мах, махан бүтээгдэхүүний экспортын стратеги 2024-2028

<sup>3</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawId=367>

<sup>4</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawId=6163>

<sup>5</sup> <https://legalinfo.mn/mn/detail/15406>



INVESTMENT AND  
TRADE AGENCY



боловсруулсан бүтээгдэхүүний экспортын хувь хэмжээг бууруулан нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ.<sup>6</sup>

### ***Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр***

Тус хөтөлбөрийн 3.3.4.16.Экспортын түүхий махны мал эмнэлэг, хорио цээрийн олон улсын шаардлагыг хангасан "Монгол мах" брэндийг хөгжүүлж, махны үнийг зах зээлийн зарчимд шилжүүлнэ.3.3.4.17.Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний эрүүл ахуй, хорио цээрийн олон улсын стандартыг нутагшуулж, гадаад худалдааны хориг, хязгаарлалтыг арилгаж, сүү, цагаан идээ, мах, ноолуур, арьс ширийг дотоод, гадаадын зах зээлд борлуулах боломжийг бүрдүүлнэ.<sup>7</sup> гэж тус тус заасан.<sup>8</sup>

### ***Монгол улсын 2024, 2025 оны жилийн хөгжлийн төлөвлөгөө***

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хавсралтын 2.1.3-д Гадаад худалдаа, экспорт хийх таатай нөхцөл, боломжийг бүрдүүлнэ. Монгол Улсын 2025 оны хөгжлийн төлөвлөгөөний хавсралтын 1.1.1.1-д Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр, Чөлөөт худалдааны хэлэлцээр, Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээрүүдийг байгуулах, гэж тус тус заасан.<sup>9</sup>

---

<sup>6</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390082532431>

<sup>7</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17141368141311>

<sup>8</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17141368141311>

<sup>9</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17142247261431&type=3>

### 3. Өнөөгийн нөхцөл байдал

#### 3.1. Монголын эдийн засгийн экспортын өнөөгийн байдал

Монгол Улс 2025 онд нийт 163 оронтой худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 27.0 тэрбум ам.долларт хүрсэн. Үүнээс экспорт 15.7 тэрбум ам.долларт, импорт 11.3 тэрбум ам.долларт хүрч гадаад худалдааны тэнцэл 4.4 тэрбум ам.долларын ашигтай гарсан байна.<sup>10</sup>

Монгол улсын нийт экспортын орлогын 93 хувийг уул уурхайн бүтээгдэхүүн дангаараа бүрдүүлж эдийн засгийн төрөлжилт сул байгаа нь манай улсын эдийн засгийн хамгийн эмзэг цэг болж байна. Эдийн засгийн төрөлжилтийг бий болгох, уул уурхайн бус салбарын үйлдвэрлэл, төрөлжилтийг нэмэгдүүлж, экспортын зах зээлийг тэлж, худалдааг хөнгөвчлөх чиглэлээр бодит ажлуудыг хийх хэрэгцээ шаардлага өндөр байна.

Түүнчлэн нийт экспортын 89.3 хувь, үүнээс уул уурхайн бүтээгдэхүүний 91.1 хувийг, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний 61 хувийг зөвхөн БНХАУ-д экспортолж байгаа нь гадаад худалдааны хамаарал хэтэрхий нэг туйлт байгааг, эдийн засгийн аюулгүй байдалд сөрөг нөлөөтэй түвшинд хүрснийг илтгэж байна. Өөрөөр хэлбэл, нэг улс болон цөөн нэр төрлийн бүтээгдэхүүнээс хамааралтай байгаа эдийн засгийн бүтцийг өөрчилж, олон худалдан авагчид өргөн хүрээний бараа нийлүүлэх тогтолцоог бий болгох зайлшгүй шаардлага бий болсон байна.

#### 3.2. Монголын махны экспортын өнөөгийн байдал

2025 онд 18 улсруу мах махан бүтээгдэхүүнийг мах экспортолсон ААНБ-ын тоо. Монгол улс 2025 оны эцэст 58.1 сая толгой мал тоолуулсан бол 20.6 сая мал эдийн засгийн эргэлтэд оруулжээ. 2020-2024 онд улсын дунджаар 600мянган тонн мах үйлдвэрлэн бэлтгэн нийлүүлдэг. Үүнээс экспортын боломж 25% буюу 150мян.тн гэж тооцож байна.

### Монгол Улсын Экспортын бүтэц болон статистик мэдээлэл






Хүснэгт1. Монгол Улсын Экспортын бүтэц болон статистик мэдээлэл

Монгол Улсын Экспортын бүтэц, 2025 он		Экспортын статистик 86 улсад
Уул уурхай 93%	Уул уурхайн бус 7%	БНХАУ 89.3%
Нүүрс 5.8 тб.\$	Ноос ноолуур 394.6 сая \$	Швейцар 6.9%
Зэс 5.8 тб. \$	Мах, махан 313.7 сая \$	АНУ 0.8%
Алт 1.2 тб.\$	Самар 41.8 сая \$	ОХУ 0.4%
Бусад УУБ 1.7 тб.\$	Арьс шир 3.5 сая \$	Иран 0.4%
	Бусад УУББ 405.4 сая \$	Бусад улс орон 2.2 %

Source: ГЕГ, УСХ

<sup>10</sup> Гаалийн ерөнхий газрын Хяналт, хорио цээрийн газар, Махны экспортын судалгаа 2025 он



	36.5%	77.6 сая ам.\$
	4.9%	10.5 сая ам.\$
	0.1%	0.2 сая ам.\$
	57.5%	122.2 сая ам.\$
	1.0%	2.1 сая ам.\$

Хүснэгт 2. Мах, махан бүтээгдэхүүн экспортолсон 18 улсын мэдээлэл, ААНБ-ийн тоо<sup>11</sup>

Улсын нэр	Экспортлосон мах мян \$	Хувь хэмжээ	ААНБ-ийн тоо
Казакстан	11,206	3.5%	4
ОХУ	467	0.1%	5
Узбекстан	14,508	4.5%	8
Туркменистан	77	0.0%	2
Тажикстан	1,571	0.5%	7
Азербайжан	3,242	1.0%	9
Турк	233	0.1%	2
Ирак	200	0.1%	2
Кувейт	49	0.0%	1
Катар	1,107	0.3%	3
Арабын Нэгдсэн Эмират	139	0.0%	2
Иран	59,328	18.3%	11
БНХАУ	208,199	64.3%	10
БНАСАУ	1,700	0.5%	4
БНСУ	1,046	0.3%	5
Япон	9,876	3.1%	6


<sup>11</sup> ГЕГ, ҮСХ

<b>Вьетнам</b>	723	0,2%	3
<b>Хонконг</b>	9,876	3,1%	6

Мах, махан бүтээгдэхүүний экспорт 2025 онд тоо хэмжээ 81 мян.тн, үнийн дүн 314 сая ам.доллар болж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад тоо хэмжээний хувьд 17%, мөнгөн дүн хувьд 17% тус тус өссөн байна. Голчлон БНХАУ, Иран улс руу экспортолсон байна.

Нийт махны 68% буюу 213 сая ам.долларын боловсруулаагүй мах, дайвар бүтээгдэхүүн байсан бол 32% буюу 101 сая ам.долларын лаазалсан буюу боловсруулсан мах байсан.ЗГ-ын 2003 оны 173 тогтоолоор Мах экспортлох боломжтой 18 боомтоос ОХУ-тай 9 боомтоор, БНХАУ руу 9 боомтоор тус тус экспортолсон байна.

**График 1. Махны экспортын тоо мэдээ 2021-2025 оноор**



**Хүснэгт 3. Сүүлийн 5 жилд монгол улсаас экспортолсон тоо малын төрлөөр мян.тн**

Он	Хонь, ямааны мах	Адууны мах	Үхрийн мах	Дулааны аргаар боловсруулсан мах	Дайвар	Нийт
<b>2021</b>	0.5	8.0	-	13.4	0.9	22.8
<b>2022</b>	3.9	6.9	0.1	4.9	0.2	16.0
<b>2023</b>	12.6	32.9	0.2	32.9	1.7	80.3
<b>2024</b>	23.7	23.9	0.2	20.8	1.5	70.1
<b>2025</b>	25.1	34.6	0.04	22.6	3.3	85.6

Монгол Улсын махны экспорт нь сүүлийн 5 жилийн хугацааны статистикаас ажиглахад 2025 онд хамгийн их өсөлттэй байгаа бөгөөд ЕАЭЗХ-ны зах зээлд Монголын бараа бүтээгдэхүүн гаалийн татваргүй нэвтэрч чадсанаар зах зээлд эзлэх байр суурь, өрсөлдөх чадвараа цаашид нэмэгдүүлэх өргөн боломж бүрдэнэ. ЕАЭЗХ-ны зах зээлд нийлүүлэх мах, махан бүтээгдэхүүний экспорт 125%-140%, нэмэгдэх боломжтой байна.<sup>12</sup>

<sup>12</sup> Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын Худалдааны түр хэлэлцээр 2026 он

#### 4. Нөөц түүхий эд, үйлдвэрлэлийн суурь

##### 4.1. Монгол Улсын махны экспортын нөөц

Монгол Улс мал аж ахуйн салбарын арвин нөөцдөө тулгуурлан мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлж байна. НҮБ-ын Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын Олон улсын судалгааны төвөөс хийсэн “Монгол Улсын махны экспортыг нэмэгдүүлэх замын зураг боловсруулах судалгаа”-ны дүнгээс үзэхэд Монгол Улс жилд 170–200 мянган тонн мах экспортлох боломжит нөөцтэйбөгөөд энэ нь эдийн засгийг уул уурхайн салбараас төрөлжүүлэх чухал боломж гэж үзэж байна. 2025 оны байдлаар Монгол Улсад 58.1 сая толгой мал тоологдсон бөгөөд 20.6 сая ширхэг малыг 81 мянган тонн махыг 52 ААНБ-аар дамжуулан эдийн засгийг эргэлтэд оруулсан нь махны үйлдвэрлэл, экспортын түүхий эдийн хангалттай суурь нөөц бүрдсэнийг харуулж байна. Монголын махны экспортын цаашдын төлөв нь 150 мянган тонн мах экспортлох боломжтой хэмээн үзэж байна.

##### 4.2. Монгол улсын махны үйлдвэрлэлийн суурь

Сүүлийн жилүүдэд төрөөс махны салбарыг хөгжүүлэх чиглэлээр бодлого, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, боловсруулах үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд анхаарч МУ-ын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөний хүрээнд 17 мах боловсруулах үйлдвэр шинээр ашиглалтад орж, үйлдвэрлэлийн суурь чадавхийг нэмэгдүүлжээ.<sup>13</sup>

Монгол Улсын хэмжээнд 17 мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэр ашиглалтад орж байгаа бөгөөд түүний 13 үйлдвэр нь одоогийн байдлаар бүрэн ашиглалтад орсон байна.

Хүснэгт 4. Шинээр ашиглалтад орж буй үйлдвэрийн тоо

Аймаг	Тоо	Ахиц дэвшил, үр дүн
Орхон	2	Мал төхөөрөх хүчин чадал 879 тн/хоног өсөлттэй байна.
Булган	2	
Төв	1	Мах боловсруулах хүчин чадал 1.5 тн/хоног өсөлттэй байна.
Дархан-Уул	2	8 Мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэрийн өргөтгөл
Улаанбаатар	4	
Хэнтий	3	4 Мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмж
Ховд	2	
Баянхонгор	1	

Мах боловсруулах салбарт олон улсын HACCP болон ISO 22000 стандартууд нэвтэрч, хүнсний аюулгүй байдлын хяналт, чанарын баталгаажуулалтын тогтолцоо үе шаттайгаар бэхжиж байна. Үүнээс гадна малын эрүүл мэнд, махны гарал үүслийг бүртгэх зорилгоор цахим мэдээллийн системүүдийг нэвтрүүлж эхэлсэн нь салбарын ил тод байдлыг нэмэгдүүлэх чухал алхам болжээ.

<sup>13</sup> Хүнсний хангамж, аюулгүй байдал үндэсний хөдөлгөөн

Мөн Монгол Улс махны экспортын чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлж, мал эмнэлэг, хорио цээр, хүнсний аюулгүй байдлын чиглэлээр 53 гэрээ, хэлэлцээр байгуулсан нь гадаад зах зээлд нэвтрэх эрх зүйн орчныг бүрдүүлжээ. Хөдөө аж ахуйн салбарын экспортыг төрөлжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх нь Монгол Улсын махны салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой гэж судалгаанд дүгнэжээ.

## **5.Дотоод, гадаад, зах зээлийн боломж**

Монгол улсын махны экспорт нь 150 мян.тн байх бөгөөд дотооддоо боловсруулсан болон дээд зэргийн мах үйлдвэрлэх экспортлох нөөц бололцоог бий болгох, үйлдвэр техникийн нөхцлийг сайжруулах шаардлагатай байна. Хөвсгөл аймгийн Ханх, Дорнод аймгийн Ульхан, Эрээнцэв боомтоор малчид, мах бэлтгэн нийлүүлэгчид экспортлох бүрэн боломжтой.

### **5.1. ЕАЭЗХ-тай байгуулсан эдийн засгийн хэлэлцээр**

2023 оны 09 сард ОХУ-ын Владивосток хотноо зохион байгуулагдсан Дорнын эдийн засгийн чуулга уулзалтын үеэр цөөн нэр төрлийн бараа дээр ЕАЭЗХ-той чөлөөт худалдааны түр хэлэлцээр байгуулах замаар шийдвэрлэх санал тавьсан. Үүнээс хойш Монгол Улс болон Евразийн Эдийн Засгийн Холбоо, түүний гишүүн орнууд хооронд худалдааны түр хэлэлцээр байгуулах тухай албан ёсны яриа хэлэлцээг эхлүүлж, өнгөрсөн хугацаанд талууд нийт 2 удаагийн зөвлөлдөх уулзалт, 3 шатны хэлэлцээг зохион байгуулсан. “Монгол Улс болон ЕАЭЗХ, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газрын 29 дүгээр тэмдэглэлийн дагуу Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж 2025 оны 12 дугаар сарын 12-нд соёрхон батлуулсан.

Тус хэлэлцээрээр талууд нийт 367 нэр төрлийн барааг хамруулсан. ЕАЭЗХ-ны гишүүн орнууд нь дотоодын зах зээлээ хамгаалсан бодлоготой. Өмнө нь мах, махан бүтээгдэхүүний төрлийн 9 бараа гаалийн 50%-ийн татвартай экспорт хийдэг байсан бол 29 төрөл болж нэмэгдэн татвар нь 0% боллоо. Манай улсын нийт махны экспорт ЕАЭЗХ-ны улсуудын импортын 44%-ийг, арьс ширэн бүтээгдэхүүний импортын 0.1%-ийг, ноос ноолууран бүтээгдэхүүний 6%-ийг хангахаар байна. Манай экспортлохоор сонгосон бараануудыг дүнгээр нь харвал ЕАЭЗХ-ны улсуудын зөвхөн импортын хэмжээ нь л гэхэд 2023 оны байдлаар мах, махан бүтээгдэхүүн 706 сая ам.доллар, арьс ширэн бүтээгдэхүүн 6.9 тэрбум ам.доллар, ноос, ноолууран эдлэл 7.5 тэрбум ам.доллар байна.

Мөн арьс ширэн бүтээгдэхүүн, ноос, ноолууран бүтээгдэхүүн, сүү, цагаан идээ, малын гаралтай бусад бүтээгдэхүүн, малын өөх тос, чацаргана, арвай зэрэг ХАА-н бүтээгдэхүүнийг гаалийн татваргүй экспортлох нэр төрлийг нэмэгдүүллээ.

### **5.2. Төрөөс хэрэгжүүлж байгаа үндэсний хөтөлбөрүүд**

Төрөөс хэрэгжүүлж байгаа Цагаан алт, Хүнсний хувьсгал, Шинэ хоршоо зэрэг хөтөлбөрүүдээр дамжуулан хөдөө аж ахуй, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог бэхжүүлэх арга хэмжээнүүд идэвхтэй хэрэгжиж манай улсын үндэсний үйлдвэрлэгчид 180 сая гаруй хүнтэй зах зээлд татваргүй экспортолж, орлогоо нэмэгдүүлэх түүхэн боломж бий болов. Манай экспортлогч ААНБ хамгийн



багадаа 16.6 сая ам.доллар буюу 60 орчим тэрбум төгрөгийн гаалийн татвар тэглүүлэхээр байна.

## 6. Хөрөнгө оруулалтын боломжтой чиглэл

Одоо байгаа малын илүүдэл болон Хятад, Орос, Япон руу экспортлох гарц нээлттэй зэргээс шалтгаалан хөрөнгө оруулалтыг махны экспортод оруулах боломжтой бөгөөд хэд хэдэн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай. Тухайлбал, малын эрүүл мэнд дотоодын борлуулалт, экспортыг хязгаарласаар байна. Дэлхийн Амьтны Эрүүл Мэндийн Байгууллагын гэрчилгээ олгох хоригийг даван туулах шаардлагатай байна. Олон улсын зах зээлд махны тогтвортой нийлүүлэлтийг хангаж чадвал хөрөнгө оруулагчид одоо байгаа боловсруулах хүчин чадлыг (нядалгааны газар, мах боловсруулах үйлдвэр) сайжруулах эсвэл нэмэгдүүлэх хөшүүрэгтэй.<sup>14</sup>

Хүснэгт 5. Махны салбарт хөрөнгө оруулах боломжтой салбарууд


Хөрөнгө оруулах боломжит дэд салбарууд	Боломжит бүтээгдэхүүн, үйлчилгээ	Үр өгөөж, өсөлт
<b>Мах боловсруулах үйлдвэрүүд</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Хиам, консерв, бэлэн хоол</li> <li>• Халал болон бусад</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Нэмүү өртөг хүртэх боломжтой</li> </ul>
<b>Экспортын зориулалттай мах бэлтгэл, мах төхөөрөх үйлдвэр</b>	<ul style="list-style-type: none"> <li>• HACCP, ISO стандарт бүхий slaughterhouse</li> <li>• Хятад, ОХУ, Дорнодын зах зээлд зориулсан үйлдвэр</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Монгол махны чанар сайжрах, стандартыг тогтворжуулах</li> </ul>
<b>Хүйтэн хэлхээ (Cold Chain Logistic)</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Хөлдөөх агуулах</li> <li>• Тээвэрлэлтийн хүйтэн сүлжээ</li> <li>• Экспортын логистик төв</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Махны экспортыг улирлын эсрдэлийг бууруулах, үр өгөөж өндөртэй.</li> </ul>
<b>Дайвар бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Гэдэс дотор</li> <li>• Яс, арьс, өөх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Малын дайвар бүтээгдэхүүнийг ашиглалтад оруулах</li> </ul>
<b>Органик мах буюу өндөр зэрэглэлийн сорттой махны үйлдвэр</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Бэлчээрт өссөн малын органик махыг экспортлох</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Дэлхийн зах зээлд Монгол мах экспортлох</li> </ul>

## 7. Нэмүү өртөг шингээх боломж

Мах, махан бүтээгдэхүүний стратеги нь Монгол Улсын Засгийн газрын албан ёсны баримт бичиг юм. Энэхүү стратегийг Олон улсын Худалдааны төв (ОУХТ) Худалдааг хөгжүүлжх Стратегийн хөтөлбөрийнхөө хүрээнд хийгддэг үйл явц, аргачлал болон техникийн туслалцаанд үндэслэн боловсруулсан. Үүнд салбарын тэргүүлэгч байгууллагууд, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид болон төрийн байгууллагуудын төлөөллүүдийг оролцуулсан төр-хувийн хэвшлийн хэлэлцүүлгүүдийг хийж салбарын өрсөлдөх чадварын гол асуудлууд болон стратегийн хүрээнд хийгдэх нэн чухал үйл ажиллагаануудыг зөвшилцсөн. Тоон болон чанарын судалгааны зэрэгцээ нэмүү өртгийн сүлжээний дүн шинжилгээг хөгжлийн түншүүд эсвэл Монгол улсын Экспортыг дэмжих

төсөл гэх мэт одоогоор хэрэгжиж байгаа дэмжих хөтөлбөрүүдээр хийгдсэн үр дүнг үргэлжлүүлэх, мөн дотоодын зөвлөхүүдийн дэмжлэгтэйгээр хэлэлцүүлгүүдийг үргэлжлүүлэн компаниуд, байгууллагууд болон салбарын холбоодтой уулзаж ярилцлага авах зэргээр баяжуулалт хийсэн. Эдгээр ажлууд нь зах зээлийн талаарх ойлголтыг гүнзгийрүүлэхэд үнэ цэнэтэй оруулга болсон.

Схем 1. Монгол Улсын махны салбарын нэмүү өртгийн сүлжээний зураглал



Нэмүү өртгийн сүлжээний зураглал нь бүтээгдэхүүн, үйлчилгээг өөрчлөхөд зайлшгүй шаардлагатай үйл явцын бүх дарааллыг бүрэн дүрслэн харуулдаг бөгөөд үүнд анхны үзэл баримтлалаас эхлээд эцсийн хэрэглэгчдэд хүргэх, эцсийн хэрэглэгч хэрэглэх хүртэл замналыг хамардаг.<sup>15</sup>

Үндэсний хөтөлбөрүүдэд нийцтэй байдлаар нэмүү өртөг шингээж экспортыг дараах байдлаар нэмэгдүүлэх боломжтой. **Шинэ хоршоо байгуулах хөтөлбөрийн хүрээнд:**

- Малчдын амьжиргааг дээшлүүлж, малын гаралтай бүтээгдэхүүний нэмүү өртөг, логикийн сүлжээг бий болгох
- Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах

Монгол Улс нь дөврөн улирлын байгалийн мал аж ахуйтай бөгөөд энэ нь махны экспортод томоохон давуу тал болдог. Гэсэн хэдий ч, экспортын боломжийг бүрэн ашиглахын тулд дараах зүйлсийг хийх шаардлагатай:

- Махыг түүхийгээр нь экспортлохоос илүүтэйгээр, гүн боловсруулсан бүтээгдэхүүн (жишээлбэл, консерв, зайдас, утсан мах)-ийг үйлдвэрлэж, экспортлох.

<sup>15</sup> Үндэсний экспортын стратеги 2024-2028

- Мал эмнэлгийн хяналт, эрүүл ахуйн олон улсын стандартыг бүрэн хангаж, томоохон зах зээл (БНСУ, Япон,Хятад)-д нэвтрэх зэрэг боломжтой байна.

## 8. Дэд бүтэц, ханган нийлүүлэлт

Уул уурхайн бус салбараас хамгийн нөөц боломж өндөртэй салбар нь ХАА-н салбар бөгөөд Монгол Улсын хэмжээнд экспортын боломж 150 мян.тн байна. Үүнээс 2025 онд 20.6 сая мал эдийн засгийн эргэлтэд оруулсан. Манай улс жилд 450 мян.тонн мах, махан бүтээгдэхүүнд бэлтгэн, үүнээс ердөө 47 мян.тонн буюу 7.5%-ыг л экспортод гаргасан нь голчлон БНХАУ, Иран улс байна.

Засгийн газрын 2003 оны 173 тогтоол Мах экспортлох боломжтой 18 боомтыг батласан. Үүнд дараах боомтууд хамаарч байна.

Хүснэгт 6. 2025 онд мах экспортлосон боом, аймгууд

№	Мах Экспортлох боломжтой боомт	Мах Экспортлосон хэмжээ /мян.тн/	Мах экспортлосон үнийн дүн /мян, сая \$/	Мах бэлтгэн нийлүүлсэн аймаг,	Мах бэлтгэн нийлүүлсэн хэмжээ
1.	Цагааннуур	1.7 мян.тн	5,2 сая \$	Баян-Өлгий	22.2 мян.тн
2.	Боршоо	183.0 мян.тн	343.4 мян	Увс	25.3 мян.тн
3.	Тас	0.0	0.00	Завхан	27.3 мян.тн
4.	Арцсуурь	37.4 тн	131.1 мян \$	Архангай	60.2 мян.тн
5.	Ханх	0.0	0.0	Хөвсгөл	56.5 мян.тн
6.	Сүхбаатар	13.3 мян.тн	44.7 сая \$	Булган	38.6 мян.тн
7.	Алтанбулаг	183.0 мян.тн	343.4 мян	Сэлэнгэ	27.9 мян.тн
8.	Ульхан	0.0	0.0	Дорнод	45.0 мян.тн
9.	Эрээнцав	0.0	0.0	Хэнтий	31.3 мян.тн
10.	Хавирга	0.0	0.0	Баянхонгор	24.9 мян.тн
11.	Баянхошуу боомт	0.0	0.0	Төв	58.1 мян.тн
12.	Бичигт	0.0	0.0	Сүхбаатар	38.9 мян.тн
13.	Замын-Үүд	31.3 мян.тн	120.2 сая \$	Дорноговь	28.3 мян.тн
14.	Ханги	25.0 тн	89.7 мян. \$	Дундговь	29.4 мян.тн
15.	Гашуунсухайт	0.0	0.0	Өвөрхангай	34.3 мян.тн
16.	Шивээхүрэн	25.0 тн	108.4 мян \$	Өмнөговь	19.6 мян.тн
17.	Бургастай	0.0	0.0	Говь-Алтай	19.8 мян.тн
18.	Булган	0.0	0.0	Ховд	15.1 мян.тн
19.	-	-	-	Орхон	2.4 мян.тн
20.	-	-	-	Дархан-Уул	5.3 мян.тн
21.	-	-	-	Улаанбаатар	6.5 мян.тн
22.				Говьсүмэр	5.2 мян.тн

Мах экспортлох боломжтой 18 хилийн боомтоос 8 боомтоор л мах гаргасан байна. Үүнээс ОХУ-тай хиллэдэг Цагааннуур, Боршоо, Арцсуурь, Сүхбаатар, Алтанбулаг боомтоор мах гаргасан байна. Цаашид Хөвсгөл аймгийн Ханх, Дорнод аймгийн Ульхан, Эрээнцэв боомтоор малчид, мах бэлтгэн нийлүүлэгчид экспортлох бүрэн боломжтой.

Хүснэгт 7. ОХУ болон БНХАУ-ын боомтын тоо болон хилийн үнэ.

1 кг махны үнэ, 2025 он				
Хиллэдэг боомтын тоо	Үхрийн мах	Хонины мах	Ямааны мах	Адууны мах
Монгол Хилийн үнэ	4 ам.\$	4 ам.\$	4 ам.\$	3.6 ам.\$
ОХУ 16 боомт	8 ам.\$	11 ам.\$	15 ам.\$	10 ам.\$
БНХАУ 13 боомт	12 ам.\$	12 ам.\$	16 ам.\$	17 м.\$

## 9. Эрсдэл, импортын хорин болон татварын дарамт

### 9.1. Махны салбарт тулгамдаж буй асуудлууд

Монгол улсын үхрийн мах, махан бүтээгдэхүүний экспорт үндсэндээ хөгжөөгүй хэвээр байна. Монгол Улс үхэр сүргийн тоо толгой ихтэй, үйлдвэрлэлийн ихээхэн чадавхтай хэдий ч хамгийн бага хэмжээний боловсруулалттай үхрийн махны экспорт хязгаарлагдмал байгаа, дотоодын зах зээл дэх үхрийн махны бүтээгдэхүүнд голлон анхаарсаар байна. 2025 онд үхрийн махны экспорт ердөө 0,2 сая ам долларын орлого олсон бөгөөд энэ нь цөөхөн улс руу экспортлосон байна. <sup>16</sup> Монгол улсын үхрийн махны экспортод доорх хүчин зүйлүүдээс хамаарч хязгаарлагдмал байдаг. Үүнд:

- **Өвчний дэгдэлт:** Монгол Улс шүлхий өвчин гарсан түүхтэй учраас импортын хатуу зохицуулалттай улс руу үхрийн мах экспортлоход хүндрэлтэй байдаг.
- **Үйлдвэрлэлийн зардал өндөр:** Малын ашиг шим багатайгаас үүдэн Монголд үхрийн мах үйлдвэрлэх өртөг өндөр байгаа нь Монголын үйлдвэрлэгчдийг бусад орны үйлдвэрлэгчид, ялангуяа хөлдөөсөн махны зах зээлийн сегментэд өрсөлдөхөд хүндрэл учруулж байна.
- **Хүйтэн сүлжээний дэд бүтэц хязгаарлагдмал:** Хүйтэн сүлжээний бүтэц хязгаарлагдмал, хүйтэн агуулах, хөргүүртэй машин байхгүй зэрэг нь үхрийн мах, ялангуяа шинэ мах экспортлоход хүндрэл учруулж байна.
- **Экспортын квот, нөөц:** Үндэсний хүнсний аюулгүй байдлыг хангах зорилгоор экспортын квот, нөөцийг бий болгож байгаа нь экспортыг улам хязгаарлаж байна.
- **Дамжин өнгөрөх тээврийн хязгаарлалт:** Монголын үхрийн махны экспортын ачааг БНХАУ-аар дамжин өнгөрөхийг хориглосон бөгөөд оронд нь ОХУ болон Владивосток боомтоор дамжин өнгөрөх шаардлагатай байгаа нь экспортын зардал, хүндрэлийг нэмэгдүүлж байна. <sup>17</sup>

<sup>16</sup> ГЕГ,

<sup>17</sup> Монголын махны стратеги 2023 он,

## 9.2. Экспортын мах, махан бүтээгдэхүүний гаалийн хорио цээрийн хяналт


Мах экспортлоход дараах шаарлагыг хангасан байх нөхцлийг тусгасан байдаг.<sup>18</sup>

- Импортлогч улстай тохиролцсон хорио цээрийн нөхцөл, эсхүл хорио цээрийн талаархи Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенци, олон улсын байгууллагаас гаргасан стандарт, удирдамж, зөвлөмжид нийцсэн байх
- Экспортын шаардлага хангаж буйг нотолж эрх бүхий байгууллагаас гэрчилгээ олгосон байх.

Зураг 1, 2, 3. Монгол Улсын мэргэжлийн хяналтын ерөнхий газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Чанарын хяналт, шалгалт хорио цээрийн ерөнхий газар хооронд Монгол Улсаас БНХАУ-д Адууны махан бүтээгдэхүүний экспортлох үеийн хяналт шалгалт, хорио цээрийн хамтын ажиллагааны протокол



<sup>18</sup> Гаалийн ерөнхий газрын Хяналт, хорио цээрийн газар 2026 он



Хүснэгт 8. Малын мах экспортлоход тавигдах шаардлага

Экспортын хяналт	өмнөх	Экспортын хяналт	үеийн	Тээвэрлэлтийн үеийн үндсэн шаардлага	Дамжуулан өнгөрүүлэхэд тавих шаардлага
Экспортлох бүтээгдэхүүнээс дээж авч лабораторийн шинжилгээнд хамруулах		Баримт бичгийн хяналт		Тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл	Амьтны гоц халдварт өвчин гараагүй тайван улс, бүсээс зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэсэн байх,
Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагаас тогтмол мэдээлэгдэх мал, амьтны гоц халдварт өвчний мэдээлэлд үндэслэн халдвартай бүс нутгаас гаралтай эсэхийг баталгаажуулах		Биет үзлэг хаяг шогшонь мал эмнэлгийн экспортын		Дулаан тусгаарлагчтай Тэвш, бүхээгтэй	Бүтээгдэхүүний чингэлэгийн лац, ломбо бүрэн бүтэн байх.
Экспортын гэрчилгээ олгох.		Гэрчилгээнд бичигдсэн мэдээ мэдээлэлтэй тохирч буй		Хөргөлтийн төхөөрөмжөөр тоноглогдсон Тэмдэглэл, бүртгэлтэй	Дамжуулан тээвэрлэх үед тухайн байгууллагын зөвшөөрөлгүйгээр тээврийн хэрэгслээс буулгахгүй байх

“Амьтан ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай”<sup>19</sup> хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу **экспортын шаардлага хангаж буйг нотолж эрх бүхий байгууллагаас гэрчилгээ олгосон байх** шаардлагатай.

- Импортлогч талд хүлээн зөвшөөрөгдсөн болон харилцан тохиролцсон загвар дагуу гэрчилгээ олгогдсон эсэх.

<sup>19</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawId=38>



INVESTMENT AND  
TRADE AGENCY



- Экспортын гэрчилгээнд бичигдсэн мэдээлэл нь бараа, бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ, хаяг шошгын мэдээлэлтэй таарч тохирч буй эсэхийг шалгаж баталгаажуулна.

Хүснэгт 9.Холбогдох экспортын зах зээл болон сегментүүдэд мөрдөгддөг импортын тариф

Улс/ зээл БТКУС	БНХАУ	ОХУ	Казакстан	Узбекистан	Япон	БНСУ	ЕХ
0201- Үхрийн шинэ эсвэл хөргөсөн мах	Гулууз: 20% Хэрэглэсэн :12%	11.25%	Үндэсний тарифын шугамын кодоос хамааран 11.25% ба 30%	0%	38.5%	40%	12.8%+евро 176.8/100кг
0202- Үхрийн хөлдүү мах	Гулууз: 25% Хэрэглэсэн :12%	As above	Дээрхтэй ижил	0	38.5%	40%	Квот тариф 20% 12.8%+евро 176.8/100кг****
0204-Хонь, ямааны шинэ, хөргөсөн эсвэл хөлдүү мах	15% Доорхоос бусад нь: Хөлдөөсөн хонины гулууз:23% Ястай хонины хөлдөөсөн зүсэлт: 12% Ямааны мах: 20%		11.25%	0%	0%	22.50 %	
0205- Адууны мах	20%	11.25%	11.25%	0%	0%	27%	0%*****
0206- Хүнсний дайвар мах	Үхрийн дайвар мах- 12% Хонь, ямааны дайвар мах- 20% Хонь, ямааны дайвар мах, шинэхэн буюу хөргөсөн:1 8%	Эмийн зориулалтта й шинэхэн буюу хөргөсөн үхрийн дайвар мах: 0% Шинэ буюу хөргөсөн үхрийн дайвар мах:11.25% Хөлдөөсөн үхрийн хэл:12.26% Хөлдөөсөн үхрийн дайвар мах(хэлнээс бусад):9.38% Эмийн зориулалтта й хөлдөөсөн үхрийн дайвар мах:3.75%		20%	Үхрийн дотор мах:12.80% Малын дотор мах (Малын дотор үхрээс бусад малын):0%	18%	БТКУС 0202- ын дагуу
050400- Мал амьтны өлөн гэдэс давсаг, гүзээ	9%	3.75%					0%*****
160250 160290	5%					16025 0:72% 16029 0:30%	16.60%

Дээрх хүснэгтэд Холбогдох экспортын зах зээл болон сегментүүдэд мөрдөгддөг импортын тарифын мэдээллийг харууллаа. Энэхүү тариф нь махны эдийн засагт ил болон болон далд байдлаар нөлөө үзүүлдэг. Иймд энэхүү тарифыг хөнгөлөх зайлшгүй шаардлагатай хэмээн Махны холбоо тайлбарласан байдаг.

- Манай Улсын мах үйлдвэрлэлийн 98 гаруй хувийг бэлчээрийн малын мах бүрдүүлж байна;
- Байгаль, цаг агаар, улирлын байдлаас шалтгаалан махны үйлдвэрлэл, нийлүүлэлт тогтвортой биш, байнгын хэлбэлзэлтэй байдаг;
- Хүн амын физиологийн хэрэгцээнээс 4-5 дахин их махыг мал аж ахуйгаас нийлүүлж байна.
- Улсын хэмжээнд мал төхөөрөх үйлдвэр 118; Суурилагдсан хүчин чадал нь жилд 343.0 мян.тн; Ашиглалт 10% хүрэхгүй хувьтай;
- Мах экспортлох эрх бүхий үйлдвэрийн хүчин чадал 174.6 мян.тн байгаа; Түүнийг мөн бүрэн дүүрэн ашиглаж чадахгүй байна.
- Мах үйлдвэрлэлийг цаашид нэмэгдүүлэх нэг чухал нөөц бол сүрэгт эзлэх хээлтэгч малын хувийн жинг зохистой түвшинд хүртэл өсгөх явдал юм. Махны үйлдвэрлэл, экспорт өндөртэй гадаад улсын тайлан, мэдээллээс харахад сүргийн доторх хээлтэгч малын эзлэх хувийн жинг 60-70 хувьд хүртэл өсгөж болдог байна.

### **9.3. Махны салбарын байгаль орчинд үзүүлэх нөлөө**

Монголын мал аж ахуйн салбар нь соёл, нийгэм, эдийн засгийн чухал үүрэг гүйцэтгэдэг ч байгаль орчинд үзүүлж буй нөлөөлөл нь улам бүр нэмэгдэж байна. Мал аж ахуйн үйлдвэрлэл, мах боловсруулахтай холбоотой байгаль орчны зарим гол асуудал нь дараах байдалтай байна. Үүнд:

- Бэлчээрийн даац хэтрэх: Бэлчээрийн даац хэтэрсэн нь хөрсний эрүүл мэнд, ургамлын бүрхэвчинд сөргөөр нөлөөлж, улмаар бэлчээрийн ашиг шим буурч, малын эрүүл мэнд, тэжээллэг чанар муудаж, малын тэжээлд сөргөөр нөлөөлдөг. Энэ нь байгалийн амьдрах орчныг эвдэж, зэрлэг ан амьтдад нөлөөлж, урт хугацааны экологийн үр дагавар бүхий биологийн олон янз байдлыг алдагдуулахад хүргэдэг.
- Хүлэмжийн хий: (ХХ)-н ялгарал Мал аж ахуйн үйлдвэрлэл нь хүлэмжийн хийн ялгаруулалт, ялангуяа хоол боловсруулах болон бууц задрах үеийн метан ялгаралтын томоохон хэмжээг бий болгодог. Эдгээр хий нь нүүрстөрөгчийн давхар ислийг бодвол дэлхийн дулаарлыг илүү ихээр нэмэгдүүлдэг бөгөөд уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлдөг.
- Усны хэрэглээ ба бохирдолт: Мал аж ахуй нь малын унд, цэвэрлэгээ, тариалангийн усалгааны ажилд их хэмжээний ус шаарддаг. Ихэвчлэн усны ойролцоо бэлчээснээр усны бохирдлыг нэмэгдүүлж, усны нөөцийг эрчимтэй ашигласнаар орон нутгийн усны хангамжийг сааруулдаг. Түүгээр ч зогсохгүй малын хог хаягдал, малын фермийн бохир ус нь ойр орчмын усан санг бохирдуулж, усны бохирдолд хүргэдэг.

- Хог хаягдал үүсгэх ба менежмент: Мал аж ахуйн үйл ажиллагаа нь өтөг бууц зэрэг хатуу хог хаягдлыг бий болгодог бөгөөд энэ нь хог хаягдлын зохистой менежментгүйгээр бохирдол, байгаль орчны доройтолд хүргэдэг.
- Уур амьсгалын өөрчлөлт: Уур амьсгалын өөрчлөлт, тэр дундаа хатуу ширүүн өвөл (зуд), ган гачиг нь малын эрүүл мэнд, ашиг шимд нөлөөлж, олон мянган толгой малыг хорогдуулж байна. Монгол орны бэлчээрийн хэт хомсдол, бэлчээрийн доройтол нь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг улам нэмэгдүүлж, хөрсний элэгдэл, ус хадгалах чадварыг бууруулж байна. Энэ нь эргээд ган гачиг, цөлжилтийн нөлөөг эрчимжүүлж, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөнд орон нутгийн экосистемийн өртөмхий эмзэг байдлыг нэмэгдүүлдэг.

Эдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд уламжлалт амьжиргаа болон Монгол Улсын хэмжээнд байгаль орчныг хамгаалах тэнцвэртэй арга барилыг шаардлагатай. Өнөөгийн стратегид тусгагдсан тогтвортой, хариуцлагатай туршлагыг “Монголын махны салбарын боломж бололцоог чөлөөлж нээхийн тулд өртгийн сүлжээнд томоохон өөрчлөлт хийх шаардлагатай байна. Салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд ирээдүйн өртгийн сүлжээг ногоон стандартын шаардлагыг хангах, дижитал хувиргалт хийх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар хөгжүүлнэ хэсэгт боловсруулсан болно.

## **10. Дүгнэлт, санал**

Монгол улсын экспортын гол бүтэц болох махны экспортын салбарт шийдвэрлэх шаардлагатай хэд хэдэн системийн шинжтэй асуудал байсаар байна.

Юуны өмнө Монгол Улсын махны экспортын зах зээл хэт төвлөрсөн бүтэцтэй хэвээр байна. Одоогийн байдлаар экспортын ихэнх хувь нь БНХАУ-ын зах зээлд төвлөрч байгаа нь зах зээлийн эрсдэлийг нэмэгдүүлж, нэг улсын бодлого, худалдааны нөхцөлөөс хэт хамаарах эрсдэлийг бий болгож байна. Мөн нийлүүлэлтийн сүлжээний тогтолцоо бүрэн төлөвшөөгүй байгаа нь экспортын тогтвортой нийлүүлэлтэд хүндрэл учруулдаг. Малчид, түүхий эд бэлтгэгчид, ченжүүд, мах боловсруулах үйлдвэрүүдийн хооронд урт хугацааны гэрээт нийлүүлэлтийн тогтолцоо сул байгаа нь махны чанар, нийлүүлэлтийн хэмжээнд улирлын хэлбэлзэл үүсгэдэг байна. Түүнчлэн малын эрүүл мэнд, вакцинжуулалтын хамрагдалт, анхан шатны бэлтгэл, хадгалалтын нөхцөл орон нутгийн түвшинд жигд бус байгаа нь экспортын стандарт шаардлагыг хангахад тодорхой бэрхшээл үүсгэдэг байна.

Логистикийн асуудал мөн салбарын өрсөлдөх чадварт хүчтэй нөлөөлж байна. Монгол Улс далайд гарцгүй орон тул транзит тээврээс өндөр хамааралтай бөгөөд хүйтэн хэлхээний дэд бүтэц, агуулах, тээврийн сүлжээ хангалтгүй байгаа нь экспортын зардлыг нэмэгдүүлдэг. Ялангуяа алслагдсан зах зээлүүд болох Персийн булангийн орнуудруу мах экспортлоход агаарын тээврийн өртөг өндөр, харин зарим чиглэлд газар дамжин өнгөрөх тээврийн боломж хязгаарлагдмал байдаг. Мөн төрийн байгууллагуудын мэдээллийн систем бүрэн интеграцчлагдаагүй, экспортын зөвшөөрөл болон гэрчилгээжүүлэлтийн шат дамжлага олон байгаа нь бизнес эрхлэгчдийн хувьд хугацаа, зардлыг нэмэгдүүлэх хүчин зүйл болж байна.



INVESTMENT AND  
TRADE AGENCY



Иймээс судлаачид махны экспортын хөгжлийг зөвхөн үйлдвэрлэлийн асуудал гэж үзэхээс илүү бодлого, зах зээл, логистик, мах бэлтгэх хүчний хүний нөөц, нийлүүлэлтийн сүлжээний уялдаанд тулгуурласан цогц шинэчлэл шаардлагатай гэж үзэж байна.

Цаашид экспортын үйл ажиллагааг бүрэн цахимжуулах, хүйтэн хэлхээний дэд бүтцийг өргөжүүлэх, гаалийн зэрэглэлийг нэмэгдүүлэх, мөн экспортын зах зээлийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.